
ҮНЭТ ЦААСЫГ ЗУУЧЛАГЧ АНДЕРРАЙТЕРЫН КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

Брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхэлдэг “БиДиСЕК” ХК нь 2010 оны 10 сарын 11-ны өдөр “Силикат” ХК-ийн шохойн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, технологийг шинэчлэх, шинэ тоног төхөөрөмж худалдан авах болон санхүүгийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор нэмэлт санхүүжилт татахад зуучлах андеррайтерын гэрээг байгуулсан.

Уг гэрээний хүрээнд “Силикат” ХК-ийн олон нийтэд гаргасан нийт 170,126 ширхэг хувьцааг 177 ширхэгт хуваан, нэмж 16,222,300 ширхэг хувьцааг зах зээлд 225 төгрөгөөр санал болгон худалдаж 3,6 тэрбум төгрөг татан төвлөрүүлэх ажил хийгдэх юм.

“БиДиСЕК” ХК нь 1995 онд байгуулагдсан бөгөөд хөрөнгийн зах зээл дээр тасралтгүй 15 жил үйл ажиллагаа явуулж буй андеррайтер, брокер, дилер хөрөнгө оруулалтын зөвлөхийн компани юм. Манай компани 2006 оны 6-р сард зохион байгуулалтын хэлбэрээ өөрчлөн олон нийтэд өөрийн хувьцааг санал болгон арилжаалан хөрөнгийн зах зээл дээрээс 1,0 тэрбум төгрөг, 2008 онд нэмэлт хувьцаа гаргаснаар хөрөнгийн зах зээлээс нийт 3.7 тэрбум төгрөгийн хөрөнгийг татан төвлөрүүлж үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөтгөн ажиллаж байна.

Манай компани нь Андеррайтерийн үйлчилгээ үзүүлдэг ууган компаниудын нэг бөгөөд 2005 оны 6-р сарын 07-ны өдрийн 34 тоот тогтоолоор Андеррайтерийн үйлчилгээ эрхэлэх тусгай зөвшөөрөл авсан юм. Монголын Хөрөнгийн зах зээл дээр 2005-2008 онд нийт 13 компани шинээр үнэт цаас гаргах замаар хөрөнгө оруулалт татан төвлөрүүлсэн бөгөөд “БиДиСЕК” ХК нь 8 хувьцаат компанийн Андеррайтераар ажилласан.

Мөн 2004, 2005 онд “Пума групп”-ийн Пума бонд, 2005 онд “Монинжбар” ХК-ийн “Бүтээн байгуулалт бонд”, 2007 онд “Нийслэл өргөө” ХК-ийн “Нийслэл өргөө бонд”-ын ерөнхий зуучлан борлуулагч, 2004 онд “МСиЭС электроникс” ХХК-ийн “МСиЭС электроникс бонд”-ын туслан гүйцэтгэгчээр тус тус ажилласан дадлага туршлагатай.